



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/437

Хэрлэн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ний 103 дугаар тушаалаар батлагдсан Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 2.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны 8 дугаар сарын 31-ний Б/14 тоот тушаалаар худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн И.Баасанжав нь Төрийн албанаас (албан тушаалаасаа) чөлөөлөгдсөн тул Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ц.Мягмар-Ариунааг хавсралтад дурдсан төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны нарийн бичгээр томилсугай.

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжилтын эх үүсвэр	Төсөвт өртөг (сая.₮)	Захирамжийн дугаар, огноо
1	"Монголын нууц товчоо" цогцолборын барилгын интерьер, гадна тохижилт, гадна шугам сүлжээ (Хэнтий, Дэлгэрхаан сум)	Улсын төсөв	2700,0	A/191 2022.04.12
2	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адрага, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон) Багц3- (Баян-овоо, Дадал, Бэрх тосгон)	Улсын төсөв	4002,6	A/90 2022.02.24
3	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг (Улсын хэмжээнд)- 7:Гүрмийн нуур (Хэнтий аймаг, Баян-Овоо сум)	Улсын төсөв	100,0	A/92 2022.02.24
4	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажил, арга хэмжээ (Хэрлэн сум) багц1- тоног төхөөрөмж, багц3 - шинээр худаг гаргах, багц4- ойжуулалт, ойн зурвас байгуулах, арчлах ажил	Орон нутгийн хөгжлийн сан	235,9	A/208 2022.04.18
5	Шинэ суурьшлын бүсэд 0.4-ийн агаарын шугам байгуулах (Батноров сум)	Орон нутгийн хөгжлийн сан	181,6	A/141 2022.03.15
6	"Монголын эзэнт гүрний мини парк" тохижилт, гэрэлтүүлэг, гадна цахилгаан хангамж	Орон нутгийн хөгжлийн сан	500,0	A/210 2022.04.18
7	Хөдөө аж ахуйн хөгжлийн төвийн засвар, тохижилт	Орон нутгийн хөрөнгө оруулалт	410,0	A/184 2022.04.06
8	"Хэрлэн" соёл амралтын хүрээлэн зураг төсөл	Орон нутгийн хөрөнгө оруулалт	100,0	A/211 2022.04.18
9	Соёлын төвийн барилгын их засвар (Хэнтий, Хэрлэн сум, 5 дугаар баг)	Орон нутгийн хөрөнгө оруулалт	414,3	A/56 2022.02.09
10	4-р цэцэрлэгийн гаднах талбай, төв замаас орох хэсгийн зам	Замын сан	60,0	A/207 2022.04.18
11	Замын нөхөөс, явган хүний гэрлийн дохио (Хэрлэн сум) багц2 - авто зам засвар	Замын сан	80,0	A/204 2022.04.18
12	Гэр хорооллын хайрган хучилттай авто замын засвар (Хэрлэн сум)	Замын сан	360,0	A/212 2022.04.18
13	Мал төхөөрөх бага оврын үйлдвэрийн дэд бүтэц (Баян-овоо сум)	ЗЗББУХ төсөл	250,0	A/209 2022.04.18
14	Мал төхөөрөх бага оврын үйлдвэр шинээр барих /Баян-овоо сум/	ЗЗББУХ төсөл	500,0	A/209 2022.04.18